

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Гиваагийн Мишиг	Дугаар	L128
Оршин суугаа аймаг	Сүхбаатар	Оршин суугаа сум	Мөнхаан
Төрсөн газар	Мөнхаан	Төрсөн он	Тахиа жилтэй
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хамжлагын хийд, Өндөр Майдарын хийд	Сүм хийдийн дугаар	СБМХ 062, СБМХ 064
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 9-р сарын 15	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Сүхбаатар аймаг Мөнххаан сумын Хамжлагын хийд, Өндөр Майдарын хийд

-Хуучин Баянтэрэм сүм одоогийн Баянтэрэм багийн нутагт хамаарах сүм хийдүүдийн талаар өөрийн сонссон дуулсан зүйлээ ярьж өгөхгүй юу? Ямар ямар хийдүүд байсан бэ? Бригадын төв дээр өндөр Майдарын хийд гэж байсан байх?

Тийм. Баруунтшаа Мөнххааны хийд гэж энэ хоёр л байсан. Ер нь энэ хоёр л хийд байсан даа.

-Далай вангийн хийд, Хошуу хийд үү?

Тийм. Мөнххааны хийд гэдэг чинь баруун хойшоо. Миний мэдэхийн ийм л хийдүүд байна. Дорнод аймаг гэж байсан. Энэ Сүхбаатар аймаг чинь сүүлд байгуулагдсан.

-Бид нэг тэмдэглэлтэй яваа. Энд Баянтүмэн сумд хамаарах хийдүүд нь Өндөр Майдарын хийд, Хамжлагын хийд гэж байна.

Хамжлагын хийд гэж энүүхэн хойд дээр жаахан хийд байсан юм аа.

-Та тэнд залуудаа очиж байсан үү?

Тэр хийдэд нэг их настай буурал байсан.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Хийдийн тэргүүн нь байсан уу?

Тийм. Хэн ч гэдэг байсан юм бүү мэд. Тэгэхэд би 12, 13-тай байсан.

-Та Хамжлагын хийд рүү очиж мөргөж байсан уу?

Үгүй.

-Энэ Наран булгийн энд Наран Сарангийн энгэрт хийд байсан юм уу?

Аа бас нэг хийд байсан л юм. Хамжлагын хийд ч гэсэн жаахан байж байснаа тэгээд алга болсон байх. Дээр үеийн Наран булгийн хийд гэж олигтой юм байгаагүй. Зүгээр л балгасууд байгаа биз дээ.

-Наран булгийн хийд чинь Хамжлагын хийдтэйгээ нэг байсан юм уу?

Тийм тийм.

Лам нар нь наашаа цаашаа явж хурдаг байсан юм уу?

Мөнхаан, Майдар хоёроос. Боонгийн хоолойн хийд гэж байсан.

-Та тэнд очиж мөргөж байв уу?

Үгүй үгүй.

-Наран булгийн хийд дээр очиж мөргөж байсан уу?

Үгүй ээ, үгүй.

-Цагаанчулуутын хийд гэж?

Нэг айхтар хийд гэж байгаагүй юм. Хэдэн лам нартай л байсан юм. Энэ Хамжлагынх ч арай илүү байсан байх аа. Бага байсан болохоор ээж, аавыг дагаж л нэг явж байсан болохоос тийм ийм гэж мэдэх юм алга.

-Хоолойн худгийн хийд гэж байсан уу?

Боонгийн хоолой юу?

-Үгүй ээ, Өөр хийд. Зүүн Ганжуурын хийд гэж хэлдэг.

Зүүн Ганжуурын хийд гэж мэдэхгүй юм байна. Манай Мөнхааны Ганжуурын хийд биш үү?

-Үгүй ээ, Мөнхааны цаана Баруун Ганжуурын хийд гэж байгаа. Зүүн Ганжуурын хийд нь энэ хавиар байсан болов уу?

Хоолой худаг гэдэг газар байсан гэж байгаа.

Баянхааны хоолой гэж энд айхтар хийд байгаагүй. Урагшаа Боонгийн хийд гэж л байсан. Бригадаас урагш байсан. Жаахан хийд байсан гэнэ лээ. Өнөө нэг балгасны ором бий байх.

-Тэгвэл Хоолой худгийн хийд гэж Боонгийн хоолойн хийдээ хэлж байгаа юм болов уу?

Боонгийн хоолойгоо хэлж байгаа юм аа. Тэрнээс энд бол Хоолойн хийд гэж байгаагүй. Миний мэдэх л Өндөр Майдар гэж байсан. Мөнхаан гэж байсан.

-Өндөр Майдарын хийд хэр олон ламтай, хэдэн дугантай хийд байсан бэ?

Одоо мэдэхгүй. Хэдийчинээ лам нар байсныг. Нэлээн лам нар байсан. Дуган дүүрэн л хурдаг л байсан. Хоёр угсраа ширээ байсан.Тэрэнд л хэдэн лам нар хурдаг л байсан. Манайхны ах нар ч байсан. Тэгээд л татагдах нь татагдаад тэгээд л явчихсан.Миний хоёр ах байсан. Хоёулаа явчихсан. Настай улс байсан.

-Өндөр Майдарын хийдэд хэдэн дуган байсан бэ? Майдарын дуган гэж том дуган байсан уу?

Майдарын дуган өндөр болохоос жижиг дуган байсан. Ард нь Жанрайсагийн дуган гэж байсан.Тийм хоёрхон дуган байсан. Жаахан Майдартай байсан.

-Дугануудыг нь юугаар барьсан байсан бэ? Мод уу, хөх тоосго уу?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мод байгаагүй. Туйлуу муйпуугаар л барьсан байх. Харин Мөнххаан бол их том байсан. Хойд талынх дуган жаахан мэдэгдэх юм байсан. Мал шахсаар байгаад дуусч байгаа байх аа. Мөнххааны хийдийн цамд нэг очиж мөргөж байсан. Гэхдээ тийм ч олон дуган байгаагүй.